



Сонгинохайрхан дүүргийн
**НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ГАЗАР**

Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2025 оны үйл ажиллагааны тайлан

2025 он



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР

Үйл ажилагааны чиг үүрэг

Манай газар нь харъяа дүүргийн нутаг дэвсгэрт Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх, ажил олгогч, даатгуулагчдыг нийгмийн даатгалд хамруулах, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр зардлыг хуулиар тогтоосон хугацаанд олгох, цахим үйлчилгээг нэвтрүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг.

ᠰᠣᠩᠭᠢᠨᠬᠠᠶᠢᠷᠬᠠᠨ ᠳᠡᠭᠦᠷᠭᠢ ᠨᠢᠶᠢᠭᠢᠮᠢ ᠳᠠᠠᠲᠭᠠᠯ ᠭᠠᠰᠠᠷ



Бид даатгуулагчийнхаа итгэл
найдвар, сэтгэл ханамжаар
үнэлэгдэх нийгмийн даатгалын
үйлчилгээг хүргэнэ.

Манай байгууллага 2030 он гэхэд бүх нийтийн насан туршийн нийгмийн баталгааг хангахуйц чадамжтай, нийгмийн даатгалын цогц үйлчилгээ бүхий **ДААТГАГЧ** болно.

Нийгмийн даатгалын байгууллага нь өсөн дэвших эрмэлзлэлтэй мэргэшсэн, чадварлаг, ёс зүйтэй хүний нөөцөд түшиглэн үйл ажиллагаагаа цаг үргэлжид сайжруулан, түншлэл хамтын ажиллагааг дэмжин, харилцан үр ашигтай хамтран ажиллаж, сайн засаглалыг хэрэгжүүлэн, хэрэгцээ шаардлагад нийцсэн чанартай үйлчилгээг **ДААТГУУЛАГЧДАД** хүргэнэ.

مستقیم و مستقیم از مستقیم



НДЕГ-ын даргын 2025 оны А/238 дугаар тушаалаар тус газрын бүтцийг 5 хэлтэс, 1 тасагтай, 60 орон тоогоор баталсан. 2025 оны байдлаар 60 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО (тэрбум төгрөгөөр)

	төлөвлөгөө	гүйцэтгэл
 Ажил олгогчийн шимтгэл	253,03	263,1
 Сайн дурын даатгал	21,3	11,2
 ҮОМШӨ, нөхөн, алданги	0,3	0,4
 Нийт	274,7	274,7
 Орлогын төлөвлөгөөний биелэлт	100%	

Сангийн орлого хуваарилалт (тэрбум төгрөгөөр)




316,7

/ЭМД-ийн шимтгэлийн орлого орсон дүнгээр/


НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ (тэрбум төгрөгөөр)

Тэтгэврийн даатгалын сан



Нас барсан тэтгэвэр авагч (сая төгрөгөөр)

Тэтгэмжийн даатгалын сан (тэрбум төгрөгөөр)



Ажилгүйдлийн даатгалын сан (тэрбум төгрөгөөр)




4396 иргэнд
17

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САНХҮҮЖИЛТ, ЗАРЦУУЛАЛТ

Үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл (сая.төг)

ᠮᠣᠩᠭᠡᠨ ᠠᠵᠢᠯᠢᠯᠠᠭᠠᠨᠢ ᠰᠠᠨᠬᠡᠭᠡᠵᠢᠯᠤᠳᠤ, ᠵᠠᠷᠴᠠᠭᠤᠯᠠᠯᠤᠳ



■ Төлөвлөгөө
■ Гүйцэтгэл



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХАМРАЛТ



Сайн дурын даатгалд нийт **9812** даатгуулагчид үйлчилгээ үзүүлсэн байна.

ШИНЭЭР ХАМРУУЛСАН ТОО



Ажил
олгогч

473



Сайн дурын
даатгуулагч

3376




Албан
журмын
даатгуулагч

2128

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын барагдуулалт (тэрбум)

Төгрөг



54.5 тэрбум төгрөгийн өр бүхий
3256 ажил олгогчтой биечлэн
уулзалт хийж, 31,1 тэрбум
төгрөгийг барагдуулсан.

ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ



Сар бүр цахим тайлан баталгаажуулсан ажил олгогч **4200**



Цахимаар ирүүлсэн ажилгүйдлийн **3418** тэтгэжийн хүсэлтийг хянан баталгаажуулж, тэтгэмж олгосон байна.



Цахимаар ирүүлсэн ХЧТА-ны **8087** эмнэлгийн хуудсыг хянан баталгаажуулж, тэтгэмж олгосон байна.

2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс ХЧТА-н тэтгэвэр бүрэн цахимжиж 82 хүсэлтийг шийдвэрлэсэн байна.



Цахимаар ирүүлсэн ЖА - ны **4777** эмнэлгийн хуудсыг хянан баталгаажуулж, тэтгэмж олгосон байна.

ЦАХИМААР АРХИВЫН ЛАВЛАГАА ХҮРГҮҮЛСЭН БАЙДАЛ



Аймаг, дүүргийн
НДГ -т
хүргүүлсэн 564



QR кодоор
1256




Аймаг,
дүүргийн НДГ-ээс
ирүүлсэн 612



Цахимаар ирсэн өргөдөл гомдлыг <https://erp.ulaanbaatar.mn/> програмд шууд бүртгэн, цаасан ирсэн өргөдөл гомдлыг бүртгэлийн дэвтэрт хөтөлж холбогдох хэлтэст erp програмаар шилжүүлэн шийдвэрлэлтийн явцад хяналт тавин ажиллаж байна.

Өргөдөл, гомдлын төрөл



ХЯНАЛТ ШАЛГАЛТ



Гадаад хяналт шалгалт

8 аж ахуйн нэгжид шалгалт хийж, 5 байгууллагад 20,5 сая төгрөгийн төлбөр, зөрчилд улсын байцаагчийн акт тавихаар, 3 байгууллагад зөвлөмж өгч ажилласан.



Дотоод хяналт шалгалт

Санхүү бүртгэлээс 2025 оны 01-03 сард SICOS программ дээр үүсгэсэн ажилгүйдлийн тэтгэмжийн санд нийт 32 иргэний 31.4 сая төгрөгтэй холбоотой авлагыг шалгаж буруу үүсгэсэн 14 иргэнд холбоотой 11.9 сая төгрөгийг авлагын бичилтийг залруулж, 18 иргэнд 19.5 сая төгрөгийг илүү олгосон зөрчилд улсын байцаагчийн акт бичиж шүүхэд шилжүүлэхээр ажиллаж байна.

Иргэдээс ирсэн өргөдөл гомдол, ажил олгогчоос ирүүлсэн хүсэлтийг дагуу 2025 онд 125 улсын байцаагчийн акт бичигдснээс 7 тэтгэвэр авагчдад 37,3 сая төгрөгийн, 88 ажил олгогчдод 61,8 сая төгрөгийн төлбөр, тэтгэмжийн даатгалын санд 48,6 сая төгрөг буюу нийт 480,7 сая төгрөгийн зөрчил оногдуулсан. Барагдуулалт 60% хувьтай ажилласан байна.



ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Зөрчлийн хэрэг 3, хялбаршуулсан журмаар 72 зөрчилд 35 сая төгрөгийн шийтгэлийн хуудас бичиж бүрэн барагдуулсан.



Мэдээллийн ил тод байдал

Шилэн дансны мэдээллийн санд байгууллагын сангийн мэдээлэл, үйл ажиллагааны мэдээллийг сар бүр үнэн зөв оруулж байгаа эсэхэд хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд 2024 оны 4 дүгээр улирал, 2025 оны 01-03 дугаар улирлын тайланг Сангийн яам руу хугацаанд нь илгээсэн.

Программд нийгмийн даатгалын газрын 147, сангийн 149, нийт 296 мэдээлэл оруулсан байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН МАГАДЛАЛЫН ЗӨВЛӨЛ

Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа магадлан шийдвэрлэсэн байдал



СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА

Ажил олгогчид, иргэд, даатгуулагчдад зориулсан сургалт

Нийт 14 удаагийн сургалтаар иргэд, даатгуулагчдад Нийгмийн даатгалын багц хууль тогтоомжийн талаар мэдээ, мэдээлэл хүргэн ажиллав.

Хамрагдсан хүний тоо – 1592
(давхардсан тоо)



Албан хаагчдыг чадавхжуулах сургалт

Нийт 30 удаагийн сургалтад байцаагч, мэргэжилтнүүдийг хамруулсан.

Хамрагдсан хүний тоо - 433
(давхардсан тоо)



Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын газар фейсбүүк пейж хуудсаар иргэд даатгуулагчид нийгмийн даатгалын талаар мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх цаг үеийн мэдээ, мэдээллийг тухай бүр хүргэн ажилласан.

- Пейж хуудсаны хандалт: 1,640,450 нэмэгдсэн дагагч: 7211
- 141 пост мэдээлэл бэлтгэн оруулсан
- ГБХНХЯ, НДЕГ, Сонгинохайрхан мэдээ, бусад пейж хуудсын оруулсан 441 мэдээллийг түгээсэн
- Чатаар 1088 иргэнээс ирсэн асуултад хариулан зөвлөгөө мэдээлэл өгч холбогдох асуудлыг шийдвэрлэн хариуг тухай бүр өгч ажилласан байна.



ᠠᠨᠬᠠᠠᠷᠠᠯ ᠬᠠᠨᠳᠤᠭᠤᠯᠰᠠᠨᠳ ᠪᠠᠶᠠᠷᠯᠠᠯᠠᠭᠠ.

